

# УЛААНСАН ХК

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын материал (урьдчилсан)

**2026**

# Агуулга


- ХУРЛЫН ЗАР ____________________ 3
- ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ ____________________ 5
- ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ДЭГ ____________________ 6
- ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ __________ 7
- КОМПАНИЙН ТУХАЙ ____________________ 8
- Ногдол ашиг ____________________ 8
- Санхүүгийн тайлан ____________________ 9
- ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ____________________ 10
- ХАВСРАЛТ 1. САНАЛЫН ХУУДАСНЫ ЗАГВАР ____________________ 11
- ХАВСРАЛТ 2. ТОГТООЛЫН ТӨСӨЛ ____________________ 12

# Хурлын зар

Улаансан ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2026 оны 4 сарын 29-ний өдрийн 14:00 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сэнтрал Тауэр 17 давхарт болох тул хувьцаа эзэмшигчид Та бүхнийг хүрэлцэн ирэхийг урьж байна.

Хурлаар дараах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ. Үүнд:

1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулах;
2. 2025 оны санхүүгийн тайланд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын дүгнэлтийг танилцуулах;
3. ТУЗ-ийн үйл ажиллагааны тайланг танилцуулах;
4. 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах (саналын хуудас);
5. Ногдол ашиг хуваарилах эсэх тухай ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах;
6. ТУЗ-ийн 2026 оны төсвийг батлах тухай (саналын хуудас);
7. Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах, дүрэм батлах (саналын хуудас).

Хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр нь: 2026 оны 4 дүгээр сарын 8-ны өдөр байна.

Хуралд бэлтгэх явцад Хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт бичгийн жагсаалт:

1. 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайлан;
2. 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт;
3. Хурлаар хэлэлцэх асуудалд санал өгөх Саналын хуудасны загвар;
4. Хувьцаа эзэмшигчдийн хурлын дэг;
5. Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолын төсөл.

Хувьцаа эзэмшигч та бүхэн хуралдаа итгэмжлэгдсэн төлөөлөгчөөрөө дамжуулан оролцож болох ба брокер дилерийн компаниудаар дамжуулан санал авах хуудсаар болон Ард Апп-аар саналаа урьдчилж өгөх боломжтой. Санал авах хуудсаар урьдчилж санал өгөх сүүлчийн хугацаа 2026 оны 4 сарын 28-ны өдрийн 15:00 цагт дуусна.

Мөн та бүхэн 2026 оны 4 сарын 29-ний өдрөөс өмнө ажлын өдрүүдэд ажлын цагаар өөрийн үйлчлүүлдэг үнэт цаасны компанид хандах, эсхүл Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сэнтрал Тауэр 17 давхар  хаягт иржхурлын материалтай танилцах боломжтой.

Хурлын талаар дэлгэрэнгүй мэдээллийг компанийн байранд ирж болон хурал зохион байгуулах комиссын утсаар холбоо барьж авна уу.

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сэнтрал Тауэр 17 давхар

Утас: 88884891

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС

# ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

## УЛААНСАН ХК

2026.3.18 № 26-2 Улаанбаатар хот

### ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

*Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг*
*зарлан хуралдуулах тухай*

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4, 59.10, 59.11, 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 60.4, 64 дүгээр зүйлийн 64.1, 64.4, 65 дугаар зүйлийн 65.1, 65.3, 65.4, 67 дугаар зүйлийн 67.1, 71 дүгээр зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолоор батлагдсан "Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх тухай журам", Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 3 сарын 18-ны өдрийн ээлжит [illegible] хуралдааны дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Улаансан ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал (цаашид **"Хурал"** гэх)-ыг 2026 оны 4 сарын 29-ний өдрийн 14:00 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сэнтрал Тауэрийн 17 давхарт зарлан **ХУРАЛДУУЛСУГАЙ.**

2. Хуралд оролцох эрхтэй Хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2026 оны 4 сарын 8-ны өдрөөр **ТОГТООСУГАЙ.**

3. Хурлын зарыг 2026 оны 3 сарын 23-ны өдөр Хөрөнгийн биржийн цахим хуудсаар, хоёроос доошгүй өдөр тутмын сонин болон бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан нийтэд зарласугай. Давтан зарыг 2026 оны 4 сарын 7-ны өдөр олон нийтэд **ЗАРЛАСУГАЙ.**

4. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт, гарах шийдвэрийн төсөл, саналын хуудас, танилцуулга зэрэг бусад холбоотой баримт бичгийг 2026 оны 3 сарын 27-ны өдрийн дотор үнэт цаасны компаниудад **ХҮРГҮҮЛСҮГЭЙ.**

5. Хурлын даргаар Улаансан ХК-ийн Гүйцэтгэх захирал П.Батбаярыг **ТОМИЛСУГАЙ.**

6. Дараах нэр бүхий хүмүүсийг хурал зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнээр **ТОМИЛСУГАЙ.** Үүнд:

   Хурал зохион байгуулах комиссын дарга:
   Гүйцэтгэх захирал П.Батбаяр

   Хурал зохион байгуулах комиссын гишүүд:
   ТУЗ-ийн нарийн бичгийн дарга О.Ашкүү
   Нягтлан бодогч Б.Уянга.

7. Хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг Нэгдүгээр Хавсралтаар, Саналын хуудасны загварыг Хоёрдугаар Хавсралтаар, Хурлын нийтэд хүргэх зарын загварыг Гуравдугаар Хавсралтаар, Хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой материалын жагсаалтыг Дөрөвдүгээр Хавсралтаар тус тус **БАТАЛСУГАЙ.**

8. Санал авах хуудсаар урьдчилж санал өгөх хүсэлтийн хугацааг 2026 оны 4 сарын 28-ны өдрийн 15:00 цагаар тасалбар **БОЛГОСУГАЙ.**

9. Дараах нэр бүхий хүмүүсийг хурлын Тооллогын комиссын бүрэлдэхүүнээр **ТОМИЛСУГАЙ.** Үүнд:

   Тооллогын комиссын дарга:
   О.Бямбагэрэл (Ард Секюритиз ҮЦК ХХК)
   Тооллогын комиссын гишүүд:
   Ч.Даваасүрэн (Ард Секюритиз ҮЦК ХХК)
   Б.Эрдэнэбилэг (Ард Секюритиз ҮЦК ХХК)

10. Холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хурлыг зарлан хуралдуулах, хурлын зар мэдээ хүргэх, энэхүү тогтоолыг бүрэн дүүрэн, түргэн шуурхай гүйцэтгэхэд шаардлагатай бүх арга хэмжээг авч ажиллахыг Хурал зохион байгуулах комисст **ДААЛГАСУГАЙ.**

11. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэсэн шийдвэр болон бусад материалыг Компанийн тухай хууль болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан хугацаанд Монголын хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэхийг Гүйцэтгэх захирал П.Батбаярт **ДААЛГАСУГАЙ.**

ДАРГА УЛААНСАН ХК Ч.ГАНХУЯГ

# Хувьцаа эзэмшигчдийн хурлын дэг

| Хуваарь | Хариуцах тал | Цаг |
|---|---|---|
| 1 Хурлын ирцийг бүртгэх | Тооллогын комисс | 14.00 - 14.15 |
| 2 Хурлын ирцийг мэдээлэх | Тооллогын комисс | 14.15 - 14.20 |
| 3 Хурлын дарга хурлыг нээж, хурлаар хэлэлцэх асуудал болон хурлын дэгийг танилцуулах | Хурлын дарга | 14.20 - 14.30 |
| 4 Хурлаар хэлэлцэх асуудлыг дарааллын дагуу танилцуулах, санал авах | Хурлын дарга | 14.30 - 15.00 |
| 5 Хэлэлцэх асуудал тус бүрээр санал хураалт | Тооллогын комисс | 15.00 - 15.10 |
| 6 Тооллогын комиссын тогтоолыг танилцуулах | Тооллогын комисс | 15.10 - 15.20 |
| 7 Хурлаас гарах шийдвэр, тогтоолыг танилцуулах | Хурлын дарга | 15.20 - 15.30 |

# Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал

1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулах

2. 2025 оны санхүүгийн тайланд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын дүгнэлтийг танилцуулах;

3. ТУЗ-ийн үйл ажиллагааны тайлан танилцуулах;

4. 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах;

5. Ногдол ашиг хуваарилах эсэх тухай ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах;

6. ТУЗ-ийн 2026 оны төсвийг батлах;

7. Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах, батлах

# Компанийн тухай

“Улаансан” ХК нь Монголын Хөрөнгийн Биржид 1993 оны 07 сарын 01-ний өдөр бүртгүүлсэн нээлттэй хувьцаат компани юм. Компани нь 2007 оноос хойш үйл ажиллагаа явуулаагүй. Компанийн хувьцааны хяналтын багц эзэмшигчид өөрчлөгдсөн ба 2024 оноос компанийн хувьцааны арилжааны идэвхийг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг сэргээн явуулахаар бэлтгэл ажлыг ханган, компанийг уул уурхай, ашигт малтмалын чиглэлийн аж ахуйн нэгжүүдэд хөрөнгө оруулалт хийх алсын хараатай ажиллаж байна. Компани нь хариуцлагатай уул уурхайн компаниудыг технологи, санхүүгийн хамгийн оновчтой шийдлээр дэмжих платформ юм. Платформ гэсний учир нь уул уурхайн компаниуд, нутгийн иргэд, санхүүжүүлэгч, зохицуулагчдыг нэгтгэж, уялдаа холбоотой ажиллах боломжийг бүрдүүлж ажиллах юм.

Ногдол ашиг: 2026 оны 2 дугаар сарын 16-ны өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн №26/01 тоот тогтоолоор ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн.

# Санхүүгийн тайлан (аудитлагдаагүй)

| Санхүү байдлын тайлан | 2024 Q4 | 2025 Q4 |
|---|---|---|
| **Хөрөнгө** | | |
| **Эргэлтийн хөрөнгө** | **24,500.00** | **24,500.00** |
| Мөнгө,түүнтэй адилтгах хөрөнгө | 24,500.00 | 24,500.00 |
| Татвар, НДШ – ийн авлага | 0.00 | 0.00 |
| Бусад авлага | 0.00 | 0.00 |
| Урьдчилж төлсөн зардал/тооцоо | 0.00 | 0.00 |
| **Эргэлтийн бус хөрөнгийн дүн** | **19,667,300.00** | **19,667,300.00** |
| **Нийт хөрөнгийн дүн** | **19,691,800.00** | **19,691,800.00** |
| **Өр төлбөр ба эздийн өмчийн дүн** | | |
| **Богино хугацаат өр төлбөрийн дүн** | | |
| Дансны өглөг | | |
| Татварын өр | | |
| Богино хугацаат өр төлбөрийн дүн | 0.00 | 0.00 |
| **Урт хугацаат өр төлбөр** | | |
| Бусад урт хугацаат өр төлбөр | | |
| **Өр төлбөрийн нийт дүн** | **0.00** | **0.00** |
| **Эздийн өмч** | | |
| Хувьцаат өмч | 5,595,200.00 | 5,595,200.00 |
| Эздийн өмчийн бусад хэсэг | 227,362,600.00 | 227,362,600.00 |
| Хуримтлагдсан алдагдал | -213,266,000.00 | -213,266,000.00 |
| **Эздийн өмчийн дүн** | **19,691,800.00** | **19,691,800.00** |
| **Нийт өр төлбөр ба эздийн өмчийн дүн** | **19,691,800.00** | **19,691,800.00** |

| Орлогын тайлан | 2024 Q4 | 2025 Q4 |
|---|---|---|
| Борлуулалтын орлого (цэвэр) | 0.00 | 0.00 |
| Борлуулалтын өртөг | 0.00 | 0.00 |
| **Нийт ашиг ( алдагдал)** | **0.00** | **0.00** |
| Бусад орлого | 0.00 | 0.00 |
| Борлуулалт, маркетингийн зардал | 0.00 | 0.00 |
| Ерөнхий ба удирдлагын зардал | 0.00 | 0.00 |
| Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз) | 0.00 | 0.00 |
| Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз) | 0.00 | 0.00 |
| **Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)** | **0.00** | **0.00** |
| Орлогын татварын зардал | 0.00 | 0.00 |
| **Татварын дараахь ашиг (алдагдал)** | **0.00** | **0.00** |
| **Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)** | **0.00** | **0.00** |

# Хэлэлцэх асуудлын дэлгэрэнгүй

- 1. Компанийн жилийн үйл ажиллагааны тухай:

Компани нь 2025 онд компанийн үйл ажиллагаа явуулах газраа Улаанбаатар хотруу шилжүүлсэн бөгөөд үйл ажиллагааны чиглэлээ менежментийн зөвлөгөө өгөх болгон өөрчлөж, үйл ажиллагааг сэргээн явуулах бэлтгэл ажлаа үргэлжлүүлэн хангаж ирсэн. 2026 он гарснаас хойш анхны хөрөнгө оруулалтаа уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа Стэпи нэксус МКК ХХК-нд оруулж хамтран ажиллахаар боллоо.

Санхүүгийн байдлын хувьд Компани нь жилийн эцсийн байдлаар 19,667 мян.төгрөгийн нийт хөрөнгөтэй, хуримтлагдсан алдагдал 213,266 мян.төгрөг тус тус байна. Үйл ажиллагаа явуулаагүй тул орлого олоогүй.

- 2. Хараат бус аудитын дүгнэлтийг хэлэлцэн батлах:

Компанийн жилийн санхүүгийн тайланд Санхүүгийн зохицуулах хороонд бүртгэлтэй аудитийн байгууллага гэрээгээр ажиллаж байна.

Компани аудитын дүгнэлтийг хүлээн авч, Төлөөлөн удирдах зөвлөлийн зүгээс үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн дүгнэлтийг гаргах болно.

- 3. Компанийн оноосон нэр өөрчлөх:

Компанийн үйл ажиллагааны бодлогын хүрээнд компани нь уул уурхай, ашигт малтмалын салбарт хөрөнгө оруулалт хийх, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх Стратеги төлөвлөгөөтэй уялдуулан оноосон нэрийг “Ард майнинг групп” болгон өөрчлөх саналтай байгаа тул ХЭХ-аар энэхүү асуудлыг оруулж батлах шаардлагатай байна.

- 4. Компанийн дүрмийн өөрчлөлтийг батлах:

Компанийн дүрэмд заасан оноосон нэр өөрчлөгдөж байгаатай холбоотойгоор Компанийн дүрмийн нэмэлт өөрчлөлтийг батлуулахаар хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оруулсан.

# Саналын хуудасны загвар






# Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол (төсөл)



УЛААНСАН ХК

2026.4.29 № 1 Улаанбаатар хот

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

*Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай*

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх хэсэг, Ард инвестмент групп ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2026 оны 4 сарын 29-ний өдрийн ээлжит хурлын шийдвэр болон Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Улаансан ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг **БАТАЛСУГАЙ.**

ХУРЛЫН ДАРГА П.БАТБАЯР



УЛААНСАН ХК

2026.4.29 № 2 Улаанбаатар хот

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

*Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2026 оны төсвийг батлах тухай*

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дахь хэсэг, Ард инвестмент групп ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2025 оны 4 сарын 29-ний өдрийн ээлжит хурлын шийдвэр болон Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Улаансан ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2026 оны төсвийг энэхүү тогтоолын хавсралтаар **БАТАЛСУГАЙ.**
2. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг ТУЗ-ийн дарга [illegible], Нэр дэвшүүлэх болон Цалин, Урамшууллын хороо, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороонд тус тус **ДААЛГАСУГАЙ.**

ХУРЛЫН ДАРГА П.БАТБАЯР



УЛААНСАН ХК

2026.4.29 № 3 Улаанбаатар хот

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

*Компанийн оноосон нэр өөрчлөх, дүрэм батлах тухай*

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, Улаансан ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2026 оны 4 сарын 29-ний өдрийн ээлжит хурлын шийдвэр болон Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Улаансан ХК-ийн оноосон нэрийг Ард майнинг групп болгон **ӨӨРЧИЛСҮГЭЙ.**
2. Компанийн оноосон нэрийг өөрчлөсөнтэй холбогдуулан Компанийн дүрмийн 1.4 дэх хэсэгт дараах өөрчлөлтийг оруулж, дүрмийг **БАТАЛСУГАЙ.** Үүнд:
   а/ Бүтэн нэр "Ард Майнинг Групп" ХК,
   б/ Англиар: "Ard Mining Group" Joint Stock Company
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж, эрх бүхий бүртгэлийн байгууллагад холбогдох өөрчлөлтийг бүртгүүлэхийг Гүйцэтгэх захирал П.Батбаярт **ДААЛГАСУГАЙ.**

ХУРЛЫН ДАРГА П.БАТБАЯР